



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 08 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

IX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын IX хурал 2020 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн 12:00 цагаас Төрийн ордон дахь Монгол Улсын Шадар сайдын ажлын өрөөнд 96 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтувшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд голомт бүхий улс орноос ирсэн иргэдийг тусгаарлах байрны зардал, нөхцөл байдал, хүчин чадал, цаашид энэ талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;

2. Монгол Улс-БНСҮ, Монгол Улс-Япон Улс, Улаанбаатар-Эрхүү-Улаанбаатар, Улаанбаатар-Улаан-Үд-Улаанбаатар чиглэлийн олон улсын хуваарьт нислэгийг түр зогсоосон хугацааг сунгах, Европоос ирэх зорчигчдийн тоог хязгаарлах, Улаанбаатар-Берлин-Улаанбаатар чиглэлийн нислэгийг зогсоох эсэх талаар Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;

3. “Онцгой нөхцлийн үед нүүрс, газрын тос тээвэрлэх ажлыг зохион байгуулах түр журам”-ын төслийн тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга Д.Энхсайхан;

4. Нүүрс, газрын тосны тээвэрлэлтийг сэргээх бэлтгэл ажлын явцтай танилцсан тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан;

5. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөц, хангамж, нийлүүлэлт, үнийг тогтвортой байлгах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан нарын мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэлд:

1.1. Тусгаарлах байранд байрлах 1 хүний зардлын жишиг тооцоог гаргаж Улсын онцгой комисст танилцуулж, батлуулах;

Хоёр. Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

2.1. Дэлхий дахинд өндөр хурдацтайгаар тархаад буй короновируст халдварын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан гадаадын зээл, тусlamжаар Монгол Улсад хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрийн явц, цаашдын төлөв байдлын талаар 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулах;

Гурав. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга,
Засаг дарга нарт:

3.1. Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагуудын судалгааг хийж, зөвшөөрөлтэй байгууллагуудыг хяналтад авч, үйл ажиллагааг нь хязгаарлах, зөвшөөрөлгүй буюу хууль бус үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг хаах арга хэмжээ авах;

Дөрөв. Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадралд:

4.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажилд иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс Улсын онцгой комисст өгсөн хандивыг хуваарилах, зарцуулах түр журмыг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;

Тав. Эруул мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Чинбат нарт:

5.1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 4 оронтой тусгай дугаар бүхий “Яаралтай дуудлага, мэдээллийн алба” ажиллуулах;

Зургаа. Эруул мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

6.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлгээр хязгаарлахгүйгээр Арьсны өвчин судлалын үндэсний төв, нийслэл, дүүрэг, аймгийн эмнэлгүүд, хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал зэргийг чөлөөлөх, орны тоог нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулах;

Долоо. Улсын онцгой комиссын гишүүд,
Засгийн газрын гишүүд,
аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

7.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гарсан Засгийн газрын 30, 39, 62, 63, 64, 68 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 1, 2, 3, 4 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 9 удаагийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлтийг өөрт хамаарах заалт бүрээр гарган 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улсын онцгой комиссын ажлын албанад uok@nema.gov.mn цахим хаягаар ирүүлэхийг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН